

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVIII (412)

2014

(99-104)

Жүжгийн зохиолд “Яриа”-ны үүрэг, онцлог

Г.Нарантунгалаг

Жүжгийн зохиолыг эртний утга зохиолын онолын бүтээлүүдэд тодорхойлохдоо Дандин “Зохист аялгууны толь” алдарт бүтээлдээ: жүжгийг “хавсарсан” гэж нэрлээд /энэ нь үргэлжилсэн шүлэглэсэн хэлбэрийг хавсран ашигладаг, уянга ба туульсын хоёр аргыг зохистой эвцэлдүүлэн бүтээдэг гэсэн утгаар хэрэглэжээ./ түүнийгээ “нүднээ үзэх, чихнээ сонсох хоёр ёсон бол жүжгийн зохиолын хоёр гол ёсон мөн” гээд “наатака”- буюу бүжиг, жүжиг гэсэн утгаар хэрэглэсэн байдаг. Энэ санскрит нэр томъёо нь дан бүжиг бус жүжиг, драмын зохиолыг бүхэлд нь заадаг өргөн утгатай үг юм.

Жүжгийн зохиолын дүрслэлийн гол арга нь үйл явдал, баримт, хүний сэтгэл санааны орчлонг бодотой шинжилж, хөгжил хөдөлгөөнд нь дүрийн зан төрхийг нээн харуулах зорилгоор баатруудад хэл яриа, үйлдэл хөдөлгөөний бүх тогтолцоог баатар бүрдээ хэсэглэн хуваарилж, мэргэжлийн жүжигчид түүнийг тусгай засал бүхий тайзнаа бодит мэтээр үйлдэн хэлэлцэж жүжиглэх арга юм. Жүжгийн зохиолын бичлэгийн гол арга нь харилцан яриа, харилцан үйлдэх үйлдлүүдийн /бусад тайлбар, оруулбар, тусгайлсан зөвлөмж, үйлдэл, жүжигчин болон найруулагчид зориулсан зааварчлага ч байдаг/ цогц юм.

Жүжиг нь теартын урлагт хамаарах ба жүжгийн зохиол нь уран зохиолын төрөлд хамаардаг. Жүжгийн зохиол нь туульсын болон уянгын зохиолын элементүүдийг агуулдагийн дээр тэдгээрийн дүрслэлийн аргыг ч хослуулж бүх хэрэг явдал, үйлдэл хөдөлгөөн, баатруудын хэл яриаг тус тус нарийн оноож, зохиомжлон нэгэн логикт хэлхсэн бүтцээрээ туульс /хүүрнэл/, болон уянга /яруу найраг/-ын үндсэн төрлүүдээс ялгардаг. Туульсын зохиолын жанрууд бол гол төлөв чөлөөт өрнөлттэй байдаг бол уянгын зохиолууд гол төлөв уянгын баатрын сэтгэл хөдлөл, дотоод зөрчил, зураглалд суурилдаг. Жишээ нь: Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой” /1934/ алдарт бүтээлийн эхэнд жүжгийн баатруудын нэр, нас хүйс, анги гарал зэргийг товчхон танилцуулаад цаашдаа жүжгийн өрнөлт, үйл явдлыг бүлэг, үзэгдэл, дуулалд нарийн, баатар бүрийн зан төрхийг нөхцөл байдалд нь нийцүүлэн хэсэгчлэн хуваарилж, Юндэнгийн яриа /дуу/ ба хийх үйлдлийн өмнө Юндэн, Нансалмсаагийн яриа /дуу/, үйлдлийн өмнө Нансалмаа зэргээр тэдгээрийн хэлэх үгийг нарийн оноон хуваасан байдаг нь жүжгийн зохиолын дүрслэлийн аргын онцлогоос шалтгаалж байгаа бөгөөд энэ нь жүжгийн ерөнхий байгуулалт, зохиомжийн гол онцлогийг илтгэдэг.

Харин монголчуудын бүтээсэн уламжлалт “Яриа” зохиолд баатруудын нэрийг дээрхтэй адил зориуд дурдах нь ховор бөгөөд гол төлөв хэлэлцэгчдийн ярианы хэв маяг, агуулга нь цэц булаалдсан, маргаж мэтгэсэн, ярианд хөндөгдөж буй зөрчил бүхий зангилаа асуудал буюу түүнийгээ тойрч баатрууд өөр өөрийн үзэл бодлоо шууд илтгэж, тухайн харилцагчаа уран ухаан, үг хэлний урнаар буулгаж авах, гартаах, жаргал

зовлонгоо учирлах, гэмших ба ухааралд хүрэхэд чиглэсэн уран нарийн тайлал, санаанд оромгүй эргэлттэй уран гаргалгаа шаардсан түргэн өрнөлт, гэнэтийн тайлалтай, эсвэл огт тайлалгүй төгсгөх хэв шинжүүд ажиглагддаг нь монгол аман зохиолын нэгэн ай болох “Ардын жүжиг наадмын аман зохиол”¹¹⁴ оос тодорхой харагдана.

Энэ бүхнийг өгүүлсний учир бол жүжгийн дүрслэлийн үндсэн арга, илэрхийлэл буюу хэлний бүтэц нь харилцан ярианаас бүтдэг бөгөөд эртний уран зохиолын дурсалууд болон орчин цагийн уран зохиолын хөгжлийн үе шатны өмнөхөн ба дараа үеийн богино хэлбэрийн дурсгалуудад олонтоо тааралдах “Яриа” хэмээн тодортогосн богино зохиолын дүрслэлийн үндсэн арга нь мөн харилцан яриа байгаа нь сонирхол татдаг.

Өмнө 1920-30-аад оны уран зохиолд үлэмж дэлгэрсэн харилцан яриагаар зохиомжилсон “Яриа” зохиол нь шинэ үеийн уран зохиолд жүжгийн төрөл зүйл үүсэн хөгжихөд чухал түлхэц болсон гэх нэгэн санааг цухас дурдан өнгөрсөн билээ. Харин “Яриа” зохиолд баатруудын үйлдлийг нарийн тусгадаггүй харин харилцан яриа /мэтгэлцээн, маргаан, хэрүүл, тэмцсэн үг/ гол үүрэгтэй бөгөөд бичил жүжгийн зохиолын хэлбэртэй байгаа нь эдгээр төрөл ба зүйлийн хооронд харилцан нөлөөлөл, нэг нь нөгөөгийн цаашдын хөгжилд нөлөөлж, нэгээс нөгөө рүү шилжин хувьсах боломж өргөн байгаад оршино.

Тийм ч учраас 1920-30-аад оны “Яриа” хэлбэрийн зохиол нь өөрийн хөгжлийн үе шатанд төрөл-зүйлийн үүргээ нэгэнт гүйцэтгээд жүжгийн зохиолын томоохон төрөл зүйл рүү нэгдэн нийлсэн байх шинж тэмдгүүд байдаг. “Яриа” зохиолыг сонирхох хандлага их байсны нэг учир шалтгаан бол тухайн үед ший жүжгийн зохиолыг хөгжүүлэх талаар төр засгаас их анхааран, ач холбогдол өгч “бүлгэм” байгуулан суртал ухуулахад жүжигчилсэн жижиг төрлүүд болох “харилцаа дуу”, “шог гараа”, “үзэгдэл”, “амьд сонин” мэт жүжгийн орчин үеийн жижиг хэлбэрүүд үүсч хөгжихөд ялангуяа бүрэн хэмжээний драмын бүтээлүүд хөгжих хөрс, үүтгэл уламжлал болсон байх боломж илүү байна. Үүний баримт нь С.Буяннэмэхийн “Сан до амбан буюу Ойрхи цагийн товч түүх” /1922/ тухайн үеийн монголын нийгмийн толь болсон асар том бүтэцтэй, тэр цагийн 60 гаруй түүхэн хүний үйл ажиллагааг тусгасан жүжиг гарсан нь өдгөө бүтэц байгуулалтыг үзвэл хэсэг бүлэг бүр нь биеэ даасан “Яриа” хэлбэртэй байна. Мөн Банзрагчийн “Цаг төрийн үймээний үеэр монголын сайд түшмэл, тайж, жирийн хүмүүсийн эндэж осолдсон олон тооны гэмт хэрэг” /1925/, Ши.Аюушийн “Хятадын эзэрхэг түрэмгий нараас манай гадаад монголыг өөрийн улсын нэгэн муж хэмээн үзсэний хариу захидал” /1929/, “Гадаадын хулгай буюу Хурандаа Сапайлло” /1924/ зэрэг томоохон жүжгийн зохиолууд гарсан ч бүлэг үзэгдэл бүр нь тухайн үеийн цагийн байдал, улс төрийн тэмцэл, нийгмийн гэм согог, гадаадын түрэмгийлэл гэх мэт өргөн сэдвийг нэгтгэсэн ба тэдгээр нь тус тусдаа биеэ даасан “Яриа” зохиолын чуулбар шинжтэй байгаа юм. Энэ нь “Яриа” хэлбэр зөвхөн нэг үзэгдлийг өгүүлдэг бол хэд хэдэн, бүр хэдэн арван “Яриа”-г нэгтгэн томоохон хэмжээний тайзны бүтээл туурвих эрэл хийснийг харуулдаг.

“Эдгээр жүжгүүд нь хувьсгалын үзэл суртлыг ухуулж буй...”¹¹⁵, “тухайн үеийн улс орны төрийн амьдралыг таниулах, хөрөнгөтний түрэмгий бодлогыг илэрхийлсэн үг яриа, ёгт зураг сэлтээр тодорч байна”¹¹⁶ гэсэн тодорхойлолтуудаас үзвэл нилээд зүймэл бүтэцтэй, яриа, шог ший, зураг мэт олон зүйл хавсаран сурталчилгааны зорилго

¹¹⁴ Ардын жүжиг наадмын аман зохиол УБ. 1988

¹¹⁵ Герасимович Л.К. “Литература Монгольское Народной Республики. Л. 1965 стр 31

¹¹⁶ Жамсранжав Г. Анхны алхам 1969. УБ. 150-р тал

давамгайлж байсныг харуулдаг бөгөөд чухам энэ цаг үеэс “Яриа” зохиол жүжгийн үндсэн хэсэг болж хувьссан бололтой.

Үүнээс хойш 1930-аад он гарсаар С.Буяннэмэхийн “Харанхуй засаг” /1932/, Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой” /1934/, Ши.Аюушийн “Хатан долгор, харц дамдин” /1934-1935/ зэрэг орчин үеийн жүжгийн өнгө төрхөө олсон бүтээлүүд уншигчдад хүрсэн юм.

1920-1930-аад оны дунд үеийг хүртлэх 10 гаруй жилд үндэсний жүжгийн орчин үеийн хэлбэрт хүрэх эрэл хайгуул, туршилтын он жилүүд бйасны дээр тэр хугацаанд “Яриа” хэлбэрийн жижиг зохиолууд үлэмж дэлгэрэн хөгжсөн нь цаашдаа бүрэн хэмжээний жүжгийн зохиолын туурвил зүй бүрэлдэн төлөвших, улмаар бүтцэд идэвхитэй үүрэг гүйцэтгэсээр ирсэн гэж үзэх үндэслэл болж байгаа юм.

Энэ нь цаашдаа “Яриа” хэлбэрийн зохиол огт үгүй болсон гэсэн үг биш юм. Магадгүй 1920-1930-аад оны богино хүүрнэл зохиолын төрөл зүйлийн хэлбэрээр гарч ирсэн “Яриа” зохиол ийнхүү хөгжлийн явцдаа театрчилсан жүжгийн хэлбэр рүү аажмаар шилжих хувьсал, завсрын үеийн өвөрмөц төрөл болж гарч ирсэн байж болох юм.

Ялангуяа 1940-1980-аад оны үед шүүмжлэлт санаатай, хүмүүсийн ёс суртахуун, залхуу хойрго байдал, ажил хөдөлмөрөөс хойш суугчдын дүрийг шог инээдэмт байдлаар шүүмжлэн үзүүлдэг “шог гараа”-ны төрөл зүйл, циркийн тоглолтын завсар хооронд “алиалагчдийн үзүүлбэр”-үүд бий болж, 1990-ээд он гэхэд хошин шог тоглолт /шоу/ хэлбэрээр сэргэсэн байх үндэслэл ч гаргаж болох билээ.

Жүжгийн зохиолд харилцан яриа, үйлдэлтэйгээ тохирч байх, яриа үйлдэл хоёр зөрөхгүй байх, нэмэлт тайлбар хийх, анхааруулга санамжийн тусгай оруулбарууд, үйлдэл заах зарчмууд үйлчилдэг. Харин “Яриа” хэлбэрийн зохиолд үйлдлийн үүргийг орхиж, ярианы илэрхийллийг чухалчилдаг онцлог бий. Энэ нь “Яриа” зохиол жүжгээс ялгардаг гол онцлогийн нэг юм. Жишээ нь: С.Буяннэмэхийн “Харанхуй засаг” хэмээх томоохон жүжигт:

“...Цэцэг- /дэвүүрийг авч нүүрээ илнэ/

Хатан-Чи нүүрээ илэх хэрэггүй, бушуу дэвүүрд /Цэцэг дэвүүрийг авч дахин дэвүүрдэнэ

Хөгжим эхэлнэ. Гаднаас нэг хятад худалдаачин ирнэ/Баярласан байдалтай/

Хятад-Ахайтан сайн морилж байна уу?

Хатан-Сайн, сайн

Хятад-Таны бие лагшин сайн уу. ноёнтны бие лагшин цөм сайн болов уу?

Хатан-Сайн, сайн цөм сайн. Манай түнш та сайн уу? суу, суу

Хятад-Ноён өргөөндөө морилж бий юу?

Хатан-Ноён өргөөндөө байхгүй, Хушууны хэргээр амбан ноёнд бараалхахаар явсан.

Хятад-Уухай, уухай. Тийм үү? /Энэ завсар цай өгнө/¹¹⁷ гэсэн хэсэгт бий. Үүнээс харахад жүжигт эхлээд үйлдэл, хөдөлгөөн түүнийг амилуулан тэтгэгч нь баатруудын “харилцан яриа”-ны бүрдэл чухал болох, мөн /дэвүүрийг авч нүүрээ илнэ/ гэх мэт баатрын байдал, үйлдлийг заасан тусгай зааварчлага, асуулт хариулт, сэтгэл санааны хандлага /баярласан байдалтай/, таатай таагүй байдал, эзэн зарцын харилцааны хүйтэн өнгө аяс зэргийг үндсэнд нь жүжигчний үйл хөдлөлөөр илэрхийлж, тэр нь ярианы бүрдэл хэсэгтэй нийлэгшин нэгэн цогц үзэгдэл болж агуулга нь бүрддэг бол “Яриа” зохиолд

¹¹⁷ С.Буяннэмэх “Түүвэр зохиол” УБ. 1968. 181-р тал

зөвхөн яриа нь үйлдлийг нээхэд чиглэж байдаг. Харин жүжиг нь үйлдлээр дэмжигддэг учраас “Яриа” зохиолыг бодвол ур чадвар, үйл явдлын өрнөлийн логик нь нягт, ур чадварын хувьд үзэгчдэд илүү хүрч, сэтгэл зүйд нь нөлөөлдөг бол “Яриа”-д дан яриа зонхилж, чөлөөт дүрслэл, дүрийн үйлдлийн талын мэдээлэл үгүйлэгддэг тул уран чадвар, урлалын хувьд жүжгээс дутмаг тал ажиглагддаг. Мөн амьдралыг хэт махчлан хуулбарласан нь сонирхуулан найхшруулах увидас хүч сул, уран сайхны шинж чанар нь дутагдсан байдал анзаарагддаг. Энэ нь тухайн үеийн “Яриа”-ны сул дутагдалт тал болно.

“Хувьсгалын эхний жилүүдэд нам эвлэлийн гишүүн залуучууд ажил тарсны дараа засаг төрийн бодлогыг сурталчлах, нийгэм дэх гэм дутагдлыг шүүмжлэн үзүүлж, ухуулан ойлгуулах зорилгоор богино хэлбэрийн шог гараа “Амьд сонин” хэмээх үзэгдлийг өөрсдөө найруулан биеэр жүжиглэн үзүүлдэг байсан тухай”¹¹⁸ тэмдэглэснээс үзвэл “Яриа” зохиол буюу богино хэмжээний жүжиглэхэд нийцтэй төрөл хэлбэрээр бичих нийгмийн захиалга эрэлт шаардлага их байсныг харуулах төдийгүй “Яриа” зохиол хөгжих нийгмийн захиалга, нэг чухал үүсгэл үндэс болжээ. Жишээ нь: Ц.Дамдинсүрэнгийн¹¹⁹ “Хар харгисын ярилцаан” зохиолд:

-Би зөв жолоо, шинэ залуурыг татаж бас дахин суудлаа хүснэ.

Аа тийм үү? Би юу хожимдов.

Аа чи юу! Намайг итгэх үгүй намыг дагаж, нарималзан гүйгээд явахлаар тэр. Надтай зорилго хийллээ биш үү. намаас гар!

Ер ч гаралгүй горьгүй болжээ. Гайтай шалгалт гэдэг юм болох нь шахав. Шалгалтаар хөөгсөнөөс санаагаар гарвал нэртэй. Занги, залан, мээрэн түүнчлэн цаашилбал захирагч туслагч ноён хайрхан, сайн цагийн мянган бурхан минь ээ!

Алгаа наминчлана.

Чи үзэв үү! Та одоо энэ ардын нам засгийн үед яасан муухай вэ. Тэнгэр язгуурт хан хурмастын үр садныг уруу хандуулав. Аяа цаг гэдэг бас ч жигтэй ажээ.”¹²⁰ зохиолын гол санаа нь хувьсгалаар унагаагдсан хуучин эрх ямбаа эргүүлэн авахыг битүүхэн хүсэгч дарлагч ангийнхны үнэн нүүр царай, дотор сэтгэлийг нэмэр чимэггүйгээр шинжсэн шүүмжлэлт санаа нь чухал боловч уран сайхан чанар, уран дүр, уран дүрслэлийн хувьд хангалтгүй байгааг харж болно. Харин энд байгаа нэг сонирхолтой зүйл бол жүжгийн зохиолд байдаг үйлдэл заасан тусгай тайлбар хэсэг болох “алгаа наминчлана” гэсэн хэсэг “Яриа” зохиол нь шог үзэгдэл, үзүүлбэрийн хэлбэрээр үүсээд цаашдаа том хэмжээний жүжгийн зохиолд ур чадварын хувьд шахагдан “шог гараа” хэлбэрээр хувьсаж, жүжгийн зохиолын хэлбэртэй жижиг зохиол болж хувьссан байж болох өөр нэг шинж тэмдэг гэж үзэж болно.

Жүжиг, туульсын зохиолын адил хүний амьдрал байдал, баатруудын хэрэг үйлийг харуулахын зэрэгцээ сэтгэл санааны байдлыг дүрийн үйлдэл, аяс хандлага, дохио зангаа зэргийн тусламжтай нээж бас уянгын зохиолын дүрслэлийн үндсэн элементүүдийг /ээрэг, сөрөг хэв шинж бүхий сэтгэл хөдлөлийн янз бүрийн элементүүд /дэгдлөл, ганцаардал, гуниг цөхрөл, уйтгарлал, шаналал, романтик тэмүүлэл, баяр хөөр, хөгжилтэй байдал / гэх мэтөргөн ашиглагддаг өвөрмөц төрөл. Харин “Яриа” бол баатруудын санаа

¹¹⁸ “Монголын орчин үеийн уран зохиолын түүх”. I боть УБ. 1985 он. 391-р тал

¹¹⁹ 1929 оны “Уран үгсийн чуулган”-д дээрх зохиолд зохиогчийн нэр бичээгүй боловч хожмын судлаачид Ц.Дамдинсүрэнгийн зохиол гэдгийг тогтоожээ.

¹²⁰ Хар харгисын ярилцаан “Уран үгсийн чуулган” УБ. 2013 . Монгол бичгээс хөрвүүлж, өмнөтгөл бичиж, эрхлэн хэвлүүлсэн Г.Галбаяр 61-р тал

сэтгэлийн ертөнцийг гүнзгий нээх, өрнөж буй хэрэг явдал, түүний өнгө аяс, шинж байдлыг нээж харуулах талаараа жүжгийн зохиолтой ойролцоо ч илэрхийлэх боломжийн хувьд хязгаарлагдмал, голдуу богино хэмжээтэй ёгт, шүүмжлэлт санааг илэрхийлж байжээ. Ийм шинжүүд нь уг төрөл зүйлийг жүжиглэн наадахад бус харин унгихад зориулагдсантай холбоотойн дээр уран сайхны боловсруулалт, хэл найруулгын хувьд хэтэрхий эгэл “хар яриа”-ны үгээр бүтээгдэж, амьдрал-нийгмийн шударга бусыг шүүмжлэх, эгэл үнэнийг шууд хүн, амьтны дүр зан төрхөд тохон гүтгэж шууд мэтгэлцүүлэн дүрслэдэг бичлэгийн энгийн хэлбэртэй нь холбоотой байна.

Энэ бичил жүжиглэлийн жанрын хөгжил нь Монголын шинэ тутам хөгжсөн орчин цагийн бичгийн уран зохиол руу, ялангуяа жүжгийн зохиол руу шилжих шилжилтийн үе нийгэмд театрын урлаг хөгжих таатай нөхцөл бүрэлдсэн ба амаар олон нийтэд дэлгэрэх, тархах зэрэг давуу талууд нь 1920-иод оны эхэн үеийн нийгмийн амьдрал, ард олны дунд суртал ухуулах, боловсруулан сэнхрүүлэх, урлагаар үйлчлэх олон талын хэрэгцээгээр “Яриа” хэмээх уламжлалт өвөрмөц бичил хэлбэр нв жүжгийн томоохон бүтээлүүд хөгжих, бичигдэх суурь нөхцөлийг бүрэлдүүлжээ.

1. Ялангуяа XIX зууны II хагас, XX зууны эхэн үеийн зохиолчдын бичсэн “Яриа” зохиолын уламжлал, орчин үеийн жүжгийн зохиол бичих туршлагад хүчтэй нөлөө үзүүлжээ.
2. “Яриа” зохиолын уламжлал нь социализмын он жилүүдэд ч “Шог гараа”, “Шог үзэгдэл” нэрээр тайзны урлагт соён гэгээрүүлэх, суртал ухуулах, урлагаар үйлчлэх, нийгэм дэх харш үзэгдлийг шүүмжлэх үүргээ гүйцэтгэсээр байжээ.

НОМЗҮЙ

1. Аристотель “Туурвил зүй” УБ., 1969
2. Ардын жүжиг наадмын аман зохиол УБ., 1988
3. Аюуш Ши. “Түүвэр зохиол” УБ., 1973.
4. Буяннэмэх С. “Түүвэр зохиол” УБ., 1968.
5. Герасимович Л.К. “Литература Монгольское Народной Республики. Л. 1965 стр 31
6. Жамсранжав Г. Анхны алхам УБ., 1969.
7. “Монголын орчин үеийн уран зохиолын түүх”. I боть УБ., 1985.
8. “Уран үгсийн чуулган” УБ. 2013 .

Г.Нарантунгалаг докторант

Functions and features of “Dialogue” in drama

SUMMARY

‘*Dialogue*’ is one of the distinguishing features of drama. ‘*Dialogue*’ in Mongolian literature has rapidly developed during the second half of the 19th and the early 20th centuries which connected with levels of Mongolian society, foreign exploitation, political life and people’s education. Besides, ‘*dialogue*’ as a genre had a wide range of possibilities to spread swiftly than poetry and epics since most people were illiterate.